



ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Б.АМГАЛАНЖАРГАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ДУНДГОВЬ АЙМГИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

48090 Дундговь аймаг,  
Сайнцагаан сум, Нарлаг баг  
Утас: 70-59-24-39, 70-59-22-08, 70-59-32-08  
E-mail: dundgovi@audit.gov.mn

2017.02.15 № 01/22 ДГА-2017/83/СТА-ТЦЗ

Г Зөрчил арилгуулах тухай

Аудитын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аudit хийх явцад **913,798.00** /Есөн зуун арван гурван мянга долоон зуун ерэн найман/ төгрөгийн зөрчлүүд илэрлээ.

1. Төсвийн хэмнэлтийн горимын талаар гарсан тогтоолыг зөрчин байгууллагын албан хаагчдад 213,000.00 төгрөгийн гар утасны нэгж олгосон, тэмцээн уралдаан зохион байгуулахад 250,000.00 төгрөгийг зарцуулсан байна.  
Энэ нь Улсын Их Хурлын Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2016 оны 47 дугаар тогтоолын 2.в.2-т /албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх/, мөн 2.в.5-д /төсвийн хөрөнгөөр шууд болон шууд бус хэлбэрээр шинэ жил, баяр ёслолын аливаа арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх/, Засгийн газрын 2015 оны 147 дугаар тогтоолын 6-д /Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусlamжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх/ заасныг,
2. Байгууллагын бичиг хэргийн ажилтанд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй төрийн нууцын нэмэгдэл 450,798.00 төгрөгийг олгосон.  
Энэ нь Төрийн нууцын тухай хуулийн 16.2-т /Тагнуулын байгууллагын зөвшөөрөлгүйгээр төрийн нууцыг хариуцуулахыг хориглоно./, мөн хуулийн 17.3-т /хариуцаж байгаа төрийн нууцын зэрэглэл, ажилласан хугацаанаас хамааран тухайн байгууллагад тогтоосон журмын дагуу цалингийн нэмэгдэл авах/ заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т /Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2014 оны 138 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын ажилтны нийтлэг эрх, үүргийн тухай дүрмийн 2.2.3-т /Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн аудитын байгууллагын ахлах аудитор, ахлах шинжээч, аудитор, шинжээч нь аудитын явцад

000000040


илэрсэн төлбөрийг барагдуулах, зөрчлийг арилгуулах зорилгоор төлбөрийн акт, албан шаардлага өгөх/, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 09-ны өдрийн А/95 дугаар тушаалаар баталсан Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын 4.1.3-д /Төсвийн хөрөнгийг үр ашиггүй, зориулалт бусаар батлагдсан хэмжээнээс хэтрүүлэн зарцуулж, Төсвийн тухай хуулийн холбогдох зүйл заалтыг зорчсон/ заасныг тус тус үндэслэн ШААРДАХ Нь:

1. Засгийн газрын 2015 оны 147 дугаар тогтоол болон Улсын Их Хурлын 47 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулах;
2. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй төрийн нууцын нэмэгдэл олгохыг таслан зогсоох;
3. Албан шаардлагыг хэрэгжүүлж, биелэлтийг аймгийн Аудитын газарт 2017 оны 04 дүгээр сарын 25-ны дотор албан ёсоор ируулэхийг Өндөршил сумын Засаг даргын Тамгын газрын дарга /Б.Амгаланжаргал/, нягтлан бодогч /Б.Сайхантуяа/ нарт хариуцуулав.

### АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН<sup>1</sup>:

АУДИТОР  Т.ОЮУН-ЭРДЭНЭ



ЗӨВШӨӨРСӨН:

Өндөршил сумын Засаг даргын  
тамгын газрын :

ДАРГА

Б.АМГАЛАНЖАРГАЛ

НЯГТЛАН БОДОГЧ

 Б.САЙХАНТУЯА



<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангаадаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагас тавсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулажаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлна.